



## ОУИТБС-ын Хойд бүсийн 2-р чуулганы дэлгэрэнгүй тэмдэглэл

2015 оны 6 дугаар сарын 9-ний өдөр

ОУИТБС-ын Ажлын хэсэг, ажлын алба 2015 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Сэлэнгэ аймгийн Мандал суманд “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хойд бүсийн 2-р чуулган”-ыг зохион байгуулав. Чуулганд Дархан-уул аймгийн төвөөс 2, Шарын гол сумаас 5, Орхон аймгийн төвөөс 5, Жаргалант, Баянөндөр сумаас тус бүр 5, Булган аймгаас 6, Бүрэгхангай сумаас 5, Сэлэнгэ аймгийн төвөөс 5, Хүдэр, Ерөө, Орхонтуул, Баянгол сумдаас тус бүр 10, Мандал сумаас 50 төлөөлөл нийт 160 гаруй оролцогчид оролцов. Бүртгэлийг хавсаргав.

Чуулган 10 цагт эхлэв. Хөтөлбөр ёсоор чуулганыг Мандал сумын Засаг дарга Д.Нямдаваа нээж, ОУИТБС-ын ажлын алба, Татварын ерөнхий газрын Д.Энхтуяа, Ашигт малтмалын газрын Ц.Жаргалнэмэх, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн О.Батболд, Төлсөн авснаа нийтэл эвслийн гишүүн Д.Цэрэнжав, Сорьцын албаны С.Бүрэнтогтох нар “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тухай, хойд бүсийн уул уурхайн салбарын тусгай зөвшөөрөл, татвар төлөлтийн талаар” илтгэл тавив. Орон нутгийг төлөөлж Дархан-уул аймгийн Засаг даргын орлогч Г.Баянмөнх, Булган аймгийн Байгаль орчны газрын дарга н.Гантөмөр, Орхон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Мөнх-эрдэнэ, Сэлэнгэ аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга А.Сарантуяа нар уул уурхайн одоогийн нөхцөл байдал, улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилт, түүний зарцуулалтын талаар, Бүрэгхангай, Шарын гол, Мандал сумын төлөөлөл сум орон нутагт хүлээн авдаг хандив дэмжлэг, бүтээн байгуулалтын ажлыг танилцуулсан бол Монполимет ХХК компаниудыг төлөөлж нөхөн сэргээлтийн ажлын талаар илтгэл тавьлаа. /Хөтөлбөр, илтгэлүүдийг хавсаргав./



*10:00-15:00 цаг хүртэл танилцуулгууд хийгдэж, үдийн завсарлагын дараа асуулт, хариулт, хэлэлцүүлгийн цаг эхлэв. Мандал сум бол Гацууртын уурхай буюу Ноён уулын асуудлаар иргэний нийгмийн хөдөлгөөн үүссэн онцлог сум байв. Гацууртын уурхайг ашиглахыг эсэргүүцсэн, “Ноён уулаа аваръя” хөдөлгөөний тэргүүн Цэрэннадмидаас эхний асуулт ирэв.*

Цэрэннадмид: “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал” оройтсон бороо шиг санагдаж байна. Монголын уул уурхай өнөөдөр бүх газар нутгаа сэндийчээд, Ноён уулаа хүртэл ухахдаа тулжирсэн. Гэтэл өнөөдрийг хүртэл “ил тод байдал” яагаад яригдахгүй байсан юм? Өдий болтол юу хийж явсан юм? Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонгоос “Хойд бүсийн уулзалтыг яагаад заавал Мандал суманд зохион байгуулж байгаа юм? Энэ цаг хугацаатайгаа хэр уялдаж байна вэ? Гацууртын уурхайг хурдавчлуулах гээд олигархууд улайрч буй энэ нөхцөлд, ард түмний тэмцэл өрнөж буй энэ нөхцөлд, хэр бодитой юм бэ? Оюу толгой, Таван толгой, Бороо

гоулд, Сентерра гоулд гэх зэрэг томоохон ордуудад ил тод байдал огт байдаггүй, эдгээрийг хэр ил тод болгож байна вэ? Шилэн дансны хууль хэр хэрэгжиж байгаа юм? Тони Блэйрийн талаар та илтгэлдээ дурьдлаа. Тони Блэйрийг монголд ил болон далд ирээд буцдаг ийм хүн, байгалийн баялаг ихтэй, дорой буурай орнуудад ямар үйл ажиллагаа явуулдгийг бүгд мэдэж байгаа. За та бас Бороо гоулдын уурхайгаар ороод ирлээ гэж байна. Мандал суманд үйл ажиллагаа явуулахын тулд Бороо гоулдаас виз авдаг болсон юмуу? Үүнд ямар учир байна аа? Таны илтгэл дундаас хамгийн баярлууштай үг юу байсан гэхээр “компаниуд үйл ажиллагаа явуулахын тулд хамгийн түрүүнд орон нутгийн иргэдтэй уулзсан байх ёстой, тэдний саналыг авсан байх ёстой” гэлээ. Энэ бол хамгийн чухал зүйл ээ. Хоёрдугаарт, Дэлгэрмаагаас “2004-2009 оны хооронд Бороо гоулд компани 43тн алтыг 10 жилд ухна гээд 5 жилд аваад гарахдаа улсад нэг ч төгрөгийн татвар төлөөгүй гэдэг. Тэгэхээр 43тн алт байсан нь үнэн юмуу? Үүнийг ил тод болгож чадсан уу? Гацууртын 200м гүнд Хүннүгийн бунханы дэргэд 75тн алт байгаа гэж Сентерра гоулдаас өөр хэн нотолсон юм? Монголчууд алийн болгон гадныхны үгээр явах юм? Гуравдугаарт, О.Батболдоос “Германы Лейпциг хотод 3 улсын усны шинжилгээ хийгдсэн, хариу нь надад байна. Тэр шинжилгээгээр Ноён уулын ай сав газар дахь усныхүмцэлийн агууламж байх ёстой хэмжээнээсээ 5000 дахин их байна гэсэн, энийг юу гэж үзэх юм? Олборлохоос өмнө тэр газар нутагт хичнээн төрлийн эмийн ургамал, олон наст ургамал, ан амьтан, жигүүртэн байсныг хэн тайлбарлах юм? Мэдээлэл технологийн зөвлөх Ганбатаас “Цахимаар тайланг авч, ил тод болгож байна гэсэн. Тэгвэл 2009-2014 оны Сентерра гоулдын тайланг мэдэх үү? Тэд “бусад зардалд” маш их хэмжээний мөнгө гаргасан байдаг, иргэн хүнийхаа хувьд би тэр “бусад зардал” гэдэгт хахуульд өгсөн мөнгөө тавьсан гэж харддаг. Үүн дээр тайлбар өгөөчээ. Төлсөн авснаа нийтэл эвслийн Д.Цэрэнжаваас “Та маш зөв ярьсан. Би дэмжиж байна. Гэхдээ Бороо гоулдын авсан, өгснийг ил болгож чадах уу? Сорьцын албаны С.Бүрэнтогтохоос “Гацууртын ордод хэдэн тн алт байсан юм? Хичнээн хэмжээний алт тушаасан юм? Ямар сорьцтой юм? Алтны нөөцийг танайх яаж тогтоосон юм? Бунхан байхгүй гэдгийг яаж нотлох юм? Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Жаргалнэмэхээс “Үүрийнтуяа дарга тань цахимаар л лиценз олгоод байх юм гэнэ. Монгол улсад ухагдаж, хөндөгдөхгүй алга дарам газар олдохнуу. Лиценз болгоны ард малаа байг, хүний эрх асар их хэмжээгээр зөрчигддөг, лиценз чинь тийм үнэтэй зүйл үү? Татварын хэлтсийн Энхтүяагаас “Оюу толгойн шалгалтаар зөрчил илрүүлсэн олон байцаагчдыг ажилгүй болгосон үйл явц юу болсон бэ? 2004-2009 оны хооронд хэдэн төгрөгийн татвар Бороо гоулд компани төлсөн юм бэ?” Эдгээр асуултуудад хариулт авъя.

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон “Мандал суманд бүсийн хурлыг зохион байгуулснаар ямар нэгэн буруу ойлголт төрөх вий гэсэн эргэлзээ байсан хэдий ч ОУИТБС-ын эцсийн зорилго, үүрэг бол төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх, аливаа түлгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд мэдээллээр хангах, үр дүнд хүргэх явдал юм. Тиймээс Мандал суманд ил тод байдал үр дүнтэй хэрэгжсэнээр одоогийн энэ үл ойлголцлыг даван туулахад бага ч болов тус нэмэр болох болов уу гэдэг итгэл найдварыг тээж ирсэн. Өөр ямар нэгэн санаа зорилго байхгүй. Олон улсын удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шорт технологийн дэвшил бүхий, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага хэрхэн орон нутагтайгаа харилцаж, хувь нэмэр оруулж байгааг бодитоор харах хүсэлт гаргасан тул бид Бороогийн уурхайгаар замд байдаг тул ороод гарсан. Шилэн дансны асуудал ОУИТБС-ын хамрах хүрээнд байдаггүй тул хэрэгжилтийн талаар тодорхой дүгнэлт хэлэхэд түвэгтэй байна. Тони Блэйрийн тухайд тэр хүн манай улсад ямар хэлбэрээр, ямар зорилгоор, хэзээ ирээд явсныг бид мэдэхгүй. Бидэнтэй уулзаж байгаагүй. Эл санаачилга 48 улс оронд хэрэгждэг, улс орны хөгжлийг доройтуулах бус дэмжих зорилготой. Эцэст нь хэлэхэд хэний ямар санаачилгыг хэрэгжүүлэхдээ бус энэхүү үйл явцаас орон нутаг, төр засгийн түвшинд 3 тал хамтарч ажиллаж сурах, бие биэндээ хяналт тавьж сурах хэрэгтэй байна. Тиймдээ ч орон нутагт хүрч ажиллахын тулд амралтын өдрөөсөө хугаслаад, төвөөс олон төлөөлөлтэй, сайн дураараа зүтгэл гарган ажиллаж байна” хэмээв.

Ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа ОУИТБС-ын цахим хуудас руу интернэтээр орж Бороо гоулд компанийн 2006 оноос хойш тасралтгүй ил тод байдлын тайлан

гаргасан байдал, 2006-2012 онд 229 тэрбумын төгрөгийн татварыг улсын төсөвт төлсөн, 2006 онд гэхэд 5 тэрбум татвар төлсөн талаар жил бүрийн тайлангаас харуулав. Энэ мэтчилэн ОУИТБС-ын тайлан гаргасан дүрын компанийн тайланг иргэд, олон нийт [www.eitimongolia.mn](http://www.eitimongolia.mn) цахим хуудсаар орж хүссэн мэдээллээ авч болох боломжтойг танилцуулав. Мөн нөөцийн мэдээлэл, компанийн санхүүгийн тайланд тусдаг “бусад зардал”-ын мэдээлэл ОУИТБС-ын тайланд байдаггүй тул энэ талаар мэдээлэл өгөх боломжгүйг дурьдав.

Төлсөн авснаа нийтэл эвслийн гишүүн Д.Цэрэнжав:Ноён уулыг тойрсон халуун маргаан өрнөж байна. Үнэхээр бидний бахархал болсон булш, бунхан хөндөгдөх юмуу гэдэг дээр төрийн албан ёсны баталгаатай хариу байхгүй байгаа. Бүгдээрээ эргэн санацгаая. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “орон нутгийн иргэдээс асуу” гэсэн, тэр байхгүй болсон. 4 сарын 5-ны өдөр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Ноён уулыг ашиглана, гэхдээ булш, бунхан хөндөгдөхгүй, энэ бол баталгаатай” гэж хэлсэн. Тэгэхээр энэ үгс бол дандаа улс төрчдийн үг. Би юу гэж хэлэх гээд байна гэхээр бид албан ёсны шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарыг олж харахгүй байгаа. Шинжлэх ухааны академиас “Ноён уулын булш хөндөгдөхгүй” гэсэн мэдэгдэл гаргасан. Гэтэл хэн гэдэг эрдэмтэн судалгаа хийсэн нь мэдэгдэхгүй, ямар ч нэр ус байхгүй, зүгээр хөндөгдөхгүй л гэсэн. Ийгл ТВ-ээр археологич Эрдэнэбаатар “Энэ бол эгзэгтэй, газрын дор юу байгааг бид харахгүй шүү дээ” гэсэн. Миний дүгнэлт бол албан ёсны, улс төрөөс ангид, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлтэнд хүрээгүй байна. Ийм учраас хүмүүс бухимдаад байгааг хэлмээр байна. Яагаад энэ асуудлаар олон нийтийн яриа, хэлэлцүүлэг өрнөдөггүй юм бэ? ТВ-ийн ярилцлагууд захиалгатайбайгаад байна. Тийм учраас төр засаг олон түмэнтэйгээ ойлголцлохын тулд яриа,хэлэлцүүлэг тасралтгүй хийх ёстой. Жишээлбэл Баянгол суманд юм уу, Мандал суманд ч юм уу сар бүр иргэд, олон нийттэй уулзалт, мэтгэлцээн хийж байх ёстой. Заавал бид хаа холоос ирж зохион байгуулах шаардлагагүй. Та бүгд өөрсдөө археологичдыг уриад, эдийн засагч Жаргалсайханг уриад, Уул уурхайн сайдыг уриад ингээд уулзалт зохион байгуулах ёстой. Ард түмнээсээ асуу гэж энийг хэлэх байлгүй дээ. Ийм үйл явц явагдахгүй учраас бие бие рүүгээ дайраад байна гэж харж байна. Ийм үйл явц явагдахгүй олон сарыг алдаад байна. Тэгэхээр ОУИТБС-ын чухал механизм болох олон талт оролцогчдыг оролцуулдагэнэ тогтолцоог орон нутгийн түвшинд хэлэлцүүлэг өрнүүлдэг, яриа хэлэлцээр хийдэг талбар болгон ашиглах цаг болсон. Энэ ажил цаашдаа та бүхний ажил үр дүнд хүрэхэд тодорхой хувь нэмэр оруулах болов уу гэж бодож байна.

Гамшгийн эсрэг үндэсний төв Ганбаатар гэдэг хүн байна. Танилцуулгууд сонслоо, аймаг бол ядуу юм байна, халамжийн бодлоготой, сум бол баян юм байна, компаниудаас маш их бүтээн байгуулалтын ажлуудыг хийлгэж хүлээн авсан байна. Булган аймгийн жишээг ярьлаа. Булган аймагт нөхөн сэргээлт хийсэн Пибоди компани 8 сая доллараар нөхөн сэргээлт хийгээд, 17 сая доллар гээд яриад явж байдаг. Бид гадны компаниудын энэ үгэнд хууртагдахаа больё. Компанийн нийгмийн хариуцлага гэдэг бол сум, орон нутгийн хөгжлийг дэмжих ажил биш юм. Хэрвээ дэмжиж л байгаа бол асуудалтай, нотой гэсэн үг.Үр өгөөж гэдгийг мөнгөөр бүс байгаль орчинд ээлтэй гэдгээр нь авч үздэг. ОУИТБС нэг талаар зөв боловчэхлэх гэж байгаа орд бүхий газар нутагт ирж ажилладаг нь буруу юм, эхэлчихсэн орд дээр хэрэгжүүлж болно. Орон нутгийн удирдлагууд хайгуул явагдаж буй газарт ТАН эвсэлтэй, ашиглалт явагдаж байгаа бол ОУИТБС-тай харилцахыг зөвлөж байна.

Мандал сумын иргэн:ИТХ-ын дарга ороод ирлээ. Санал хэлье. Засаг дарга яагаад оролцохгүй байгаа юм, Бороо гоулд компанийн удирдлага алга байна.Энэ 6 сард багтаад орон нутгийн бүх гишүүдийн үүлзалтыг зохион байгуулаачээ.

Цэрэннадмид: Уул уурхайн яам, Сентерра гоулд, Бороо гоулд компанийн удирдлагууд хэзээ ч иргэдтэй уулздаггүй. Дээгүүрээ л харьцдаг хүмүүс.

Хүдэр сумын иргэн: 2007 онд Сэлэнгэ аймагт ОУИТБС-ын төслийг хэрэгжүүлээд явж байлаа. Хамгийн хүнд зүйл бол олборлож байгаа бүтээгдэхүүний тоо хэмжээг тодорхойлоход хэцүү байдаг юм байналээ. Үүн дээр хяналтын асуудлыг дэвшүүлэх хэрэгтэй.Оюу толгой 2

тэрбум долларын зардал гаргасан энийг мэдэж байсан уу? Дараагийн шатны хөрөнгө оруулалт дээр хэрхэн хяналт тавих юм бэ? ОУИТБС-ын хэрэгжилтэнд ахиц гарсан байна. Интернэтэд бүх мэдээлэл байна гэдэг сайн зүйл болжээ. Хүдэр суманд Азийн сангаас 2 удаа сургалт явуулсан, үүнтэй үйлдүүлбал зүгээр байна. Бороо гоулд компанийн талаар 2, 3 гэрээг ил тод болгож байсан. Төмөртэйн хүдэр гэдэг компани байсан. 32 сая долларын төмрийн хүдэр гараад явчихлаа. Татварын алба шалгаж байна гээд хөдөлж өгдөггүй.

Булган аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Д.Буманбаяр: Өнөөдрийн бүсийн чуулганаарсалбарын үйл ажиллагаатай холбогдсон улсууд хуран чуулж, санаа бодлоо солилцож, мэдээлэл солилцож байгаад чухал, үр дүнтэй үйл явдал болж байна. Хандив, дэмжлэгийг ил тод болгодог. Гэтэл хандивын асуудал Авилгын эсрэг хуультай зөрчилддөг. Байгаль хамгаалах төлөвлөгөөг баталдаг, хянадаг хүмүүс хандив аваад байгаа. Тиймээс эдгээр хууль, тогтоомжуудыг үйлдүүлж, зөвлөмж гаргаж болох үү? Хоёрдугаарт, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн “тусгай зөвшөөрөл олгохыг орон нутаг дэмжээгүй бол бид олгодоггүй” гэж хэллээ. Гэхдээ бид дэмжихгүй ээ гээд үндэслэлээ явуулахаар хуулийн үндэслэл биш байна гээд яаж ийж байгаад л лиценз олгочихдог. Он гараад манай аймагт 32 лицензын хүсэлт ирж, сүм, орон нутаг дэмжихгүй байхад 12 лиценз олгочихлоо. Тэгэхээр таны хэлсэн үг, бодит байдал газар, тэнгэр шиг хол зөрүүтэй байна гэдгийг хэлье.

Ноён уулаа аваръя хөдөлгөөний гишүүн: Усан дахь хүнцэлийн агууламж 5000 дахин их байгаа. Энэ 60, 70тн алтыг олборлохойд ямар ч хоргүйгээр олборлох боломж байна уу?

Ц.Жаргалнэмэх: Чуулган гол сэдвийн хүрээнд ярилцах ёстой. Ноён уулын асуудлаар ярилцах гэж ирээгүй. Хувь хүн болгон өөрийн үзэл бодлоор дайрч болохгүй. Бид хуулийн хүрээнд л ажиллаж байгаа. Хуулийн хүрээнд хариулна. Хурлын сэдвийн хүрээнд асуултаа тавих хэрэгтэй. Хүнцэлийн хэмжээг 5000 дахин их гэж хаана тогтоосон юм? Ашигт малтмалын газар хүнд металлын бохирдлын хэмжээг тогтоодог лаборатори байгуулсан байгаа. Энд дээжээ өгч болно.

Төлсөн авснаа нийтэл эвслийн гишүүн Г.Чагнаадорж: Ноён уулын Цэрэннадмид та нарт баярлаж байна. Зөв сэтгэлтэй хүмүүс байна. Би та нар шиг л иргэний хөдөлгөөнөөр 13 жил явж ирсэн. Ямар үед, хаана, хэнд асуудал тавих вэ гэдгээ ялгаж салгаж бай. Өнөөдрийн сэдэв дээр тулгуурлаж ярь. Төр засаг иргэдээ оролцуулъя гээд тодорхой ажил хийгээд байна. Тэмцэгч хүн хаана ч хамаагүй яриад явж болохгүй. Үр дүн гарахгүй. Орон нутгийн удирдлага, хандивын тухай ярьж байхад зөвхөн өөрийн нутгийн төсвийн тухай л яриад байх юм. Төслийн тухай ярихгүй юм. Цаашид анхаараарай. ОУИТБС буруу юм бишээ. Сумын төв дээр өнөөдрийнх шигээ уулзалтандаа оролцоод яваарай.

Хүдэр сумын иргэн Энхсайхан: Ногоон газрыг ухах тухай асуудлыг ярьж байхад харамсалтай байна. Олборлох гээд байгаа, ухах гээд байгаа газруудад мэдээлэл өгөөчээ. 2006 оноос хойш ОУИТБС-ын талаар мэдээгүй. Алт ухахад мөнх цэвдэгийг хайлуулдаг. Хариуцлагатай уул уурхай нь голоосоо хол явдаг л юм байгаа биз, манай суманд ийм чуулган хийж өгөөчээ гэж хүсэлт тавих байна.

Мандал сумын ИТХ-ын дарга Ц.Эрдэнэхүү: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Мандалчуудын хувьд гэлтгүй Монголчуудын хувьд онцлог сэдвээр хуран чуулж байна. Өөр өөрсдийн орон нутагт тулгамдаж буй асуудлуудаар ирсэн зочид маань ярьлаа. Бидэнд ч бас асуудлууд байгаа. Олон талт зөвлөл байгуулах тухай асуудлыг Бор гуай 2 жилийн өмнөөс ажиллаж эхэлсэн. Дэд зөвлөлийн дүрмийг судаллаа. Энэ чуулганаас олон талт зөвлөл байгуулах үриалга ч юмүү тодорхой шийдвэр гаргах байх. Бид байгуулна гэхдээ асууж тодруулах зүйл байна. Өмнө нь манай суманд хэдэн лиценз байгаа нь мэдэгддэггүй байсан. 34 компани байна гэж байна. Ил тод нээлттэй болж байна. Нийт ард иргэд маань оролцоо эрчимтэй сэргэж байна. Ашигт малтмалын хууль орон нутагтай харилцах харилцааг тодорхой зохицуулж чадаагүй гэж үзэж байгаа. Гэрээ байгуулж “болно” гэдэг. Энэ нь “болохгүй” гэж

ойлгож болохоор ч юм шиг. Бүрэн зохицуулж чадахгүй байна. Баянголчууд эмзэглэж магадгүй, 50тн алтаа өгчихөөд өнөөдөр зам тавих гээд орон нутгийн хөгжлийн сангаас мөнгө гуйгаад явж байдаг. Ийм жишгийг тогтоож болохгүй л гэж манай сумын иргэд дургүйцээд байгаа юм. АМНАТ-ын 30 хувь нь тухайн орон нутагтаа үлдэнэ гэж байгаа юм, гэхдээ орон нутаг гэдэг нь аймаг юмуу, сум юмуу тэр нь бүрхэг. ИТХ хурал нь иргэдийн төлөө ч гэсэн Монгол улсын хуулийг мөрддөг. Дэд зөвлөлийг Засаг даргын орлогч ахална гэсэн байна. Үүнийг харах хэрэгтэй. ИТХурал аль талд нь байх уу? Үүрэг, оролцоо тодорхой харагдахгүй байна. Төлөөллийн ардчиллын зарчмыг үгүйсгэсэн ч юм шиг. Дэд зөвлөлийн дүрмийг зөвлөмж гэж ойлгож байгаа. Бид ямар хүмүүсээ томилохоо зөвлөлдөж байгаад гол нь харьцааг тэнцвэртэй хадгалах ёстойг өнөөдрийн зөвлөгөөнөөс ойлгож авлаа. Гарц байвал хамтдаа ярилцъя.

6-р багийн иргэн: Ноён ууланд бунхан байгаа эсэхийг нотлоогүй гэх юм. Нэг л юм хэлье. 1912 онд Богд хаант засгийн үед энэ гэээр алт байгааг илрүүлсэн. 1920 онд булш бунхан байгааг тогтоогоод алт олборлохыг хориглосон байдаг. Залуучууд түүхээ жаахан судлах хэрэгтэй. Амжилт хүсье.

Л.Бор: Засгийн газрын төлөөлж ирсэн агентлагийн охинд ахмад хүний хувьд хэлмээр байна. ОУИТБС-ын ажлын алба цаашид үүлзалт, хуралдаа Засгийн газрын байгууллагаас нөлөө бүхий хүмүүсийг оруулмаар байна. Ийм чухал арга хэмжээн дээр Засгийн газрын төлөөлж яваа хүмүүс хариуцлагатай үг хэлэх хэрэгтэй, хууль дүрмээ сайн мэдэх хэрэгтэй. Иргэд рүү дайраад, хувь хүнийхаа хувьд их эвгүй байдалтай хариулах гээд, хэрэлдүүлэх гээд, иймэрхүү уур амьсгалыг бий болгож байна. Үүний оронд хүмүүс юунд бухимдаж байна? ямар асуудал гарав гэдгийг сайн тэмдэглээж аваад, удирдлагууддаа танилцуулах ёстой. Өчигдөр хайгуул хийж байгаа үед иргэд оролцох ямар хэрэгтэй юм, ажлыг нь хийлгэ гэнээ. Хуулийн дээр хайгуул эхлэхээс өмнө иргэд оролцоно гэсэн байдаг. Орон нутгийн иргэд юу хүсч байна гэхээр одоогийн олгогдоод байгаа 3000 үүрхай хангалттай, илүү хэрэггүй, үүний ашиг тусыг хүртэж, гэрээ хэлэлцээрээ сайн хийгээчээ гээд аргаа барж, бахирч байна. Аль ч төр засгийн бодлого ард түмний сайн сайхны төлөө байдаг, төрийн бодлого хуулиар л хэрэгждэг гэдгийг сайн ойлгох хэрэгтэй.

Мандал сумын иргэн: ОУИТБС чуулганаар нөлөө бүхий асуудлыг хэлэлцлээ. Хүн болгон нэг нүхний эзэн болсон, гэтэл татвар төлдөг юмуу үгүй юмуу мэдэгдэхгүй, орон нутагт ямар алтыг хэн аваад хаагуур гаргаад байгааг мэдэхгүй ийм байдалтай байдаг. Тиймээс цаашид манай суманд хяналтын зөвлөлийг байгуулах санал дэвшүүлмээр байна. Ахмад хүний хувьд залуу боловсон хүчнүүдоюуны болоод ёс зүйдээ анхаарал хандуулахыг зөвлөж байна.

Ийнхүү хэлэлцүүлгийн төгсгөлд оролцогчид дурсгалын зураг авахуулснаар хойд бүсийн чуулган 18 цагт өндөрлөв. Чуулганыг Сэлэнгэ аймгийн ММЭ телевиз, Мандал сумын телевиз бүрэн эхээр сурвалжилсан болно.

Хянасан:

Ш.Цолмон

Тайлан бичсэн:

Б.Дэлгэрмаа